

МАНЖ ҮСЭГ БИЧИГ, СУРВАЛЖ СУДЛАЛЫН АСУУДАЛД

Л. Лувсанчүлтэм

Сонсвоос эрт цагт дорнод Гулмин шаняан апин хэмээх уул ба Хар мөрөн, Үссүри мөрний хавь газраар нутагтай таван сая орчим Манж зөрчид, Түнгүс, Хаминаган зэрэг хэд хэдэн овог аймгийн гөрөөчин, загасчин, малчин ард бол цөм Манж хэлээр яригч хүмүүс байсан гэдэг.

Манжийн төрийг үндэслэн байгуулсан Тайзу дээд Хуанди Нурхачи баатар 1599 онд Манж үсэг зохиолгох тухай Эрдэнэ Сэфу, Гагай Ха фан хэмээх хоёр хүнд тулган тушаасан бөгөөд тэр хоёулан Азийн соёлт орны үсгээс үлгэр дүрэм авч зохиохоор оролдсоор эрсээр байгаад эцэст нь манж хэлний дэслэл дараалал лугаа монгол хэл адилхан бөгөөд бараг зөрөх тонгорох үгүй байдаг тул Монголын үсгийг авч хэрэглэхэд манж хэлэнд илүү таарч тохирох ба сурч эзэмшихэд хялбар дөхөм гэж үзээд түүнийг авчээ. Тэгээд шилэн сонгож авсан Монголын уйгуржин үсгийн хэв маяг, хэлбэр дүрсийг огт өөрчлөхгүй шууд манж үгээ бичдэг болсон тул сая манж үсгийн уг эх үүсчээ.

Ингэж манж хэлтэн хүмүүс Монголын уйгуржин үсгийн албан амины ажилд явдалд хэрэглэсээр даруй хагас зуун жил болоход энэ хооронд бичсэн зохиосон бичиг хар, ном судар, асар арвин болсон бөгөөд түүнийг хожим дусал бинт үгүй бичиг гэж нэрлэжээ. Гэтэл уйгуржин үсэг нь харь орны болон ялангуяа Нангиад хэлний зарим дуу аялгууг зөв тэмдэглэхэд мөхөсдөж байсан тул Тайзон гэгээн утгат Хуандийн зарлигаар Даахай багш хэмээх нэг эрдэмтэн Манж үсгээр аливаа аялгууг тодорхой ялгавартай бичихэд мөхөсдөхгүй бүрэн хүрэлцэх болгохын төлөө Монгол үсгийн ав өвөр, хажуу хавирганд дусал бинт, зураас зартыг нэмэрлэн дохио тавьж шинэчлэсэн ба үсгийн янз үзэмжийг баахан өөр болгожээ. Дараахь хаадууд манж хэл бичгээ дотоод ба гадаад оронд түгээмэл дэлгэрүүлэх бодлого тавьж янз бүрийн сурах бичиг, сургааль бичиг, олон хэлний толь бичиг, лавлах бичиг, ярианы бичиг зохион гаргаж нийт даяар түгээн тараахын хамт манж бичгийн сургуулийн оюутан залуучуудыг алавчлан сургаад манлайд шалгарагсдад эрдмийн цол олгож, өндөр албан тушаалд дэвшүүлэх зэргээр сайшаан хөхүүлж байв. Мөн манж хэл бичгийг их дайчин гүрний улсын хэл болгон дотоод гадаадад зарлав. Энэ цагаас эхлэн бусад хэлний ном судар, бичиг харыг манж хэлэнд орчуулах хөрвүүлэх ажлыг улам ихэд өрнүүлжээ.

Жишээ нь хятад, солонгос, монгол, төвд, хотон хэлний зүйл бүрийн түүхэн роман, утга уянга, яруу найраг, үлгэр туульс, түүх домог, тууж намтар, ерөөл магтуу, гүн ухааны шаштир, болон бусад сонгодог зохиол тэргүүтэн тоолшгүй олон шилдэг ном судрыг бараг дуустал орчуулсан байнам. Бас Энэтхэгээс уламжилсан бурхан шашны зарим номыг хүртэл манж хэлэнд орчуулсан ажгуу.

Манж хэл бичгийг нэгэнт улсын хэл болгосон учир Чин гүрний засгийн газраас дотоод, гадаадтай харилцах аливаа албан бичгийг заавал манжаар бичих хууль тогтоон зарласан тул Чин гүрний бүрэл дэхүүний олон аймаг угсаатан өөрсдийн үндэсний бичгийн хамт манжаар хавсран бичих болов. Бас энэ журмыг гадаад улс нэг адил да-

гаж мөрдсөн байна. Зах жишээ нь Халхын их хүрээн дэх Оросын ерөнхий консул, Эрхүү хотын губернатор, Оросын хилийн албаныхан их хүрээний Амбан захирагчтай харилцахдаа орос бичгийн хамт ямагт Манжаар хавсран бичиж байжээ. Мөн Орос болон Европын бусад орон манж хэл бичиг сургахаар өөрсдийн оюутанг Монголын Өргөө хотын өртөө замаар Бээжинд очуулж байсан баримт материал улсын архивт үлэмж бий. Ингээд манж хэл бичиг нь Чин гүрний харьяат хүн ардын эрхбиш сурвал зохих зүйл болж, улмаар соёл боловсролын эрхэм чухал хэл болон дэлгэрч хөгжсөн байна. Ийнхүү манж хэл бичиг дотоод гадаадад тарж дэлгэрсэн боловч дагалдаагаар балран сөнөхийн байдал бас зэрэгцэн эхэлжээ.

Манж хүмүүс эрт дээр цагаас Хятадын дунд гүнзгий орж тэдэнтэй хольцолдон суурьшсан бөгөөд хүүхэд ач нар нь бага наснаас Хятадын хэл яриаг сурч, Хятадын аж амьдрал, зан ааль, заншил тэргүүтэнг дууриан дагаж аж төрсөөр даруй хятад болон хувирч байв. Манж сэхээтнүүд үндэсний хэл бичгээ хайхрахгүй таягдан хаяж дан ганц хятад хэл бичгийг ихэд сонирхон хичээнгүйлэн сурч үргэлж хэрэглэсээр эцсийн дүнд хятад болон уусжээ.

Олон он жил өнгөрөхөд манж хэл бичиг улам улам мартагдсаар ирсэнд зарим сэхээтэн сэтгэл зовниж, бид үндэстний хэлээ хаяж, албатын хэлийг авах буюу өөрсдийн соёлоо гэж бусдыг дууриах нь даанч зохисгүй, одоо манж бичиг зохиол хэдий арвин бий боловч мэдэх хүн асар цөөн болов. Настан өөдгөс барагдвал бүрэн мартана. Иймийн тул төрөлх хэл бичгээ сэргээх ёстой гэж манж нар гаслант аялгуугаар харамсан өгүүлэлдэн бичиж байжээ. Бадаргуулт төрийн үед Хатан хааны зарлигаар албан хэрэгт хятад хэл бичиг хэрэглэгтүн гэсэн учир манж хэл бичиг төрийн хэлний чанараа алдаад бүрэн сөнөх замд оржээ. Судлаачид энэ талаар бичихдээ: «Хятадчилагдах үйл явц гүнзгийрэх хирээр манж хэл бичиг аяндаа мартагдав»¹ гэжээ.

Одоо улсын түүхийн төр архивт байгаа манж хэлний маш их албан бичиг бол цаг үе нь хэдүй өнгөрсөн гэвч шинжлэл судлал хийхэд өнгөрөөгүй. Яагаад гэхэд тэдгээр бичиг баримтанд Монголчуудын нэн эртний үеийн нийгмийн амьдралыг өгүүлсэн баялаг материал агуулагджээ. Өөрөөр хэлбэл тэдгээр бичиг баримт бий болохоос өмнөх цаг үеийн байдлыг нэхэн тусгажээ. Энэ далимд дурдахад сүүлийн жилд Зөвлөлт, Унгар, Чехословакийн манжич, монголч нар ирээд архивийн материалыг судалж хэрэгтэй юмаа хуулан аваад буцсан билээ.

Одоо хэрвээ архивийн материалыг судалбал түүхийн шинжлэх ухааны хөгжилд нэмэр болох чухал юм бий.

1 Ж. Өлзий. Манж угсаатны гарал үүсэл түүх соёлын товч тэмдэглэл, «Дорнодахины судлалын асуудал» 1986. N 1 (14), т. 77.